



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 530

Улаанбаатар хот

### Хөрөнгө акталж сэлбэгээр худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 нэрийн нийт 12,510,200.00 (арван хоёр сая таван зуун арван мянга хоёр зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, сэлбэгээр худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарын бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албаны гүйцэтгэх захирал Н.Төмөрхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Сэлбэгээр худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Худалсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн

530 ... дугаар тогтоолын хавсралт

**ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ САНГИЙН АЖЛЫН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД АКТАЛЖ, СЭЛБЭГЭЭР  
ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Суудлын автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	2020 оны 104 дүгээр тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)
1	Зил-130 ачааны, 14-93 ӨВА	1993/1994	250000	5,065,200.00	500,000.00
2	Ниссан атлас-150, 53-16 ДАА, P4F23012014	1994/2002	193487	7,445,000.00	700,000.00
Нийт дүн				12,510,200.00	1,200,000.00
				(арван хоёр сая таван зуун арван мянга хоёр зуун)	(нэг сая хоёр зуун мянган)